



1251320314

I бүлэг

Газарзүйд суралцаж эхлэх нь.

7-Р АНГИ.

Хичээл №1

ГАЗАРЗҮЙН ШУ ЮУГ СУДАЛДАГ ВЭ?

A solid green horizontal bar at the bottom of the slide.

Агуулга:

1. Газарзүйн ШУ-ны судлах зүйл.
2. Байгалийн болон нийгмийн газарзүй.

1. Газарзүйн ШУ-ны судлах зүйл:

Газарзүйн ШУ нь байгаль, нийгмийн юмс үзэгдлийн тархалт, байршилт, уялдаа, холбоо, харилцан нөлөөлөл, онцлог, тэдгээрийн учир шалтгааныг цаг хугацаа, орон зайн хамааралд нь судалдаг.

ГЗ-н хичээлийг судалснаар дэлхийн бүтэц, гадаргын шинж чанар, нийгмийн үзэгдэл үйл явц, учир шалтгааныг судалж, хаана, юу, яагаад энд байгаа, цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдсөн, мөн хэрхэн өөрчлөгдөж байгааг бусдад таниулах, амьдрал ахуйдаа хэрэглэхэд туслана.



2. Газарзүйн ШУ нь байгалийн болон нийгмийн ГЗ гэж 2 салбарт хуваагдана.

БАЙГАЛИЙН ГЗ

Байгалийн ГЗ буюу физик газарзүйгээр дэлхийг бүрдүүлдэг бүх хэсгүүд, түүнд явагдах байгалийн үзэгдлийн зүй тогтол, уялдаа холбоо, учир шалтгааныг илрүүлж, хүн байгалийн харилцан үйлчлэл, байгальд үзүүлж буй эерэг сөрөг хандлагыг танин мэдэх, хайрлан хамгаалах үзлийг бий болгоно.




НИЙГМИЙН ГЗ

Нийгмийн ГЗ буюу хүмүүнлэгийн газарзүйгээр хүмүүс хаана амьдарч байгаа, соёл, зан заншлын онцлогийг орон зай, цаг хугацааны өөрчлөлттэй холбон судалдаг.

1. Байгалийн ГЗ

Гол судлах зүйл:

1. Агаар мандал
2. Чулуун мандал
3. Усан мандал
4. Шим мандал



2.Нийгмийн ГЗ

Гол судлах зүйл:

1. Хүн ам
2. Суурьшилт
3. Хөгжил

